



Оюу Толгой ХХК

Бүсийн хөгжил, нийгмийн харилцаа

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

АГУУЛГА

1	ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1	БАРИМТ БИЧГИЙН ДУГААР	3
1.2	ЗОРИЛГО	3
1.3	ХАМРАХ ХҮРЭЭ	3
1.4	ЭХЛЭХ ХУГАЦАА.....	3
1.5	ЭРХ МЭДЭЛ БОЛОН УДИРДЛАГА.....	3
2	ХАМРАХ ХҮРЭЭ.....	4
2.1	Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ	4
2.2	Бусад удирдлагын төлөвлөгөөнүүдтэй давхцах байдал	5
3	ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА.....	6
3.1	Удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийн үндсэн үүрэг хариуцлага	6
3.2	Гол уялдаа холбоо.....	7
4	ТӨСЛИЙН СТАНДАРТ.....	7
4.1	Монгол улсын холбогдох хууль болон үндэсний стандартууд	7
4.2	БОНБНУ-ийн шаардлагууд	8
4.3	Монгол улсын Засгийн газрын өмнө хүлээсэн бусад үүрэг амлалт, шаардлагууд.....	8
4.4	Зээлдүүлэгчийн стандарт болон удирдамжууд.....	8
4.5	Рио Тинто болон Оюу Толгой компанийн холбогдох стандартууд.....	8
4.6	Төслийн холбогдох стандартуудын хураангуй	9
5	УДИРДЛАГЫН ХЯНАЛТУУД.....	12
6	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ.....	15
6.1	Удирдлагын төлөвлөгөөний хяналт шинэчлэлт	15
6.2	Хэрэгжүүлэх гол үе шатууд	15
7	МОНИТОРИНГ.....	16
7.1	Мониторингийн шаардлагуудын тойм.....	16
7.2	Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд	16
7.3	Мониторингийн гол үйл ажиллагаа	17
8	СУРГАЛТ.....	20
8.1	Тойм.....	20
8.2	Танилцуулга сургалт	20
8.3	Ажлын байранд зориулсан тусгай сургалт	20
9	АУДИТ БОЛОН ТАЙЛАН.....	21
9.1	Дотоод аудит	21
9.2	Хөндлөнгийн аудит	21
9.3	Бүртгэл хөтлөлт.....	21
10	БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ	22
ХҮСНЭГТҮҮД		
	Хүснэгт 1: Үндсэн үүрэг хариуцлага	6
	Хүснэгт 2: Төслийн холбогдох стандарт	9
	Хүснэгт 3: Удирдлагын үндсэн хяналтууд	12
	Хүснэгт 4: Хэрэгжүүлэх гол үе шатууд.....	15
	Хүснэгт 5: Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд	16
	Хүснэгт 6: Мониторингийн гол үйл ажиллагаа	18

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

1 ТАНИЛЦУУЛГА

1.1 Баримт бичгийн дугаар

Энэ баримт бичиг нь Оюу Толгой (ОТ) төслийн соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө (СӨУТ) болно. Энэ удирдлагын төлөвлөгөөний баримтын дугаар RD-10-PLN-0002.

1.2 Зорилго

Удирдлагын төлөвлөгөөний зорилго нь:

- Удирдлагын төлөвлөгөөний хүрээг тодорхойлж, холбогдох удирдлагын уялдаа холбоог боловсруулах;
- Үүрэг, хариуцлагыг тодорхойлох;
- Энэ удирдлагын төлөвлөгөөтэй холбоотой төслийн стандартуудыг тоймлох;
- Энэ удирдлагын төлөвлөгөөтэй холбоотой төслийн зорилт, үйл ажиллагааны журам, удирдамжийг тодорхойлох;
- Хяналт шинжилгээ болон гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт бүхий тайлагнах журмыг тодорхойлох;
- Тодорхойлсон сургалтын шаардлага;
- Холбогдох материал болон мэдээллийн эх сурвалжийг тодорхойлох.

1.3 Хамрах хүрээ

Энэхүү удирдлагын төлөвлөгөөнд дурдсан шаардлагуудыг гэрээт гүйцэтгэгчдийг оролцуулан Оюу Толгойн бүх үйл ажиллагаанд мөрдөнө.

Энэ удирдлагын төлөвлөгөө нь 2012 оны 1 дүгээр сарын 1-нд гаргасан Рио Тинтогийн Орон нутаг, нийгмийн асуудал эрхэлсэн захирлын хариуцаж буй Рио Тинтогийн Орон нутгийн харилцааны стандартад тулгуурласан болно. Рио Тинто компаний Орон нутгийн стандартад өөрчлөлт орох тохиолдолд Оюу Толгой компаний энэ удирдлагын төлөвлөгөө мөн өөрчлөгдөж болзошгүй.

Энэ удирдлагын төлөвлөгөөг Оюу Толгой компаний Бүсийн хөгжил, нийгмийн харилцааны (БХНХ) ерөнхий менежер хариуцна. Удирдлагын төлөвлөгөөг хоёр жил тутамд нягталж шаардлагатай өөрчлөлтийг тусгах бөгөөд төслийн үйл ажиллагааны улмаас гарах өөрчлөлтийг тухай бүрт нь тусгана.

1.4 Эхлэх хугацаа

Энэ удирдлагын төлөвлөгөөг 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлнэ.

1.5 Эрх мэдэл болон удирдлага

Оюу Толгойн Гүйцэтгэх хороо энэхүү удирдлагын төлөвлөгөөг 2013 оны 9-р сарын 1-нд баталсан болно.

Оюу Толгойн Бүсийн хөгжил, нийгмийн харилцааны хэлтсийн ерөнхий менежер энэ удирдлагын төлөвлөгөөний хариуцагч байна. Удирдлагын төлөвлөгөөг өөрчлөх аливаа хүсэлтийг дээрх албан тушаалтанд хандаж гаргах бөгөөд Өөрчлөлтийн удирдлагын журмыг мөрдөнө.

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

2 ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ

Энэхүү удирдлагын төлөвлөгөө гэрээт гүйцэтгэгчдийг оролцуулан Оюу Толгойн бүх үйл ажиллагааг хамаарна. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг Соёлын өвийн удирдлагын тогтолцооны журмын дагуу хэрэгжүүлнэ. Цаашид шинээр байгуулах дэд бүтцийн талбайд соёлын өвийн үнэлгээ хийх шаардлагыг ОТ-н Газар хөндөх журам (ОТ-10-E9-PRC-0003) болон Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний хуулийн хүрээнд байгаль орчны үнэлгээ хийх явцад тодорхойлно.

Гэрээт гүйцэтгэгчид энэхүү төлөвлөгөөг хэрэгжилүүлэхийг Гэрээт гүйцэтгэгчийн удирдлагын хүрээнд тусгасан болно (ОТ-07-PLN-0001).

Соёлын өв – Тодорхойлолт

Оюу Толгой компани Рио Тинтогийн Орон нутгийн стандартад тодорхойлогдсон соёлын өвийн тодорхойлолтыг хэрэглэдэг бөгөөд энэхүү тодорхойлолт нь Рио Тинтогийн дэлхий даяар явуулж буй үйл ажиллагаанд ашиглагддаг болно. Соёлын өвийг стандартад дараахь байдлаар тодорхойлсон болно:

Орон нутагт ёс уламжлалын дагуу өв уламжилсан буюу түүхэн ач холбогдолтой орон нутгийнхны бүгдийн хүлээн зөвшөөрсөн нотолгоот зүйлс. Нотолгоот зүйлс нь биет буюу барилга байгууламж, үйлдвэрийн байгууламж, технологи, газар нутаг, түүхэн олдворууд болон биет бус, тухайлбал, хэл, зураг, хөгжим, урлаг болон зан заншил байж болно.

Стандартад мөн соёлын өвийн эд зүйлсийг дараахь байдлаар тодорхойлжээ:

Өнгөрсөн, одоо, ирээдүй үеийн соёлын, сүсэг бишрэлийн, гоо зүйн, түүхэн, шинжлэх ухааны, судалгааны буюу нийгмийн ач холбогдолтой газар буюу эд зүйл. Үүнд уламжлалыг өвлөсөн хүмүүст “ариун дагшин” онцгой ач холбогдолтой газар, тухайлбал, оршуулгын газар, тэмдэглэлт үйл явдал зохион байгуулдаг газар, хадны бичээс, худаг, уул даваа буюу домгийн буюу түүхэн үйл явдалтай холбоотой бодит зүйлс багтана. Мөн орон нутаг, бүс нутаг, үндэсний болон олон улсын хэмжээний барилга байгууламж, археологи, үйлдвэрлэл, палеонтологи, түүх, шашны буюу соёлын ач холбогдол бүхий газар нутаг, туурь байж болох ба эдгээр нь мөн хуулийн дагуу тодорхойлогдсон байж болно.

Соёлын өвийн дээрх тодорхойлолтуудыг Соёлын өвийн хөтөлбөрт тусгасан бөгөөд биет болон биет бус соёлын өвийн үнэт зүйлс хадгалагдаж буй Өмнийн говийн бүс нутгийн соёлын өвийн үнэт зүйлсэд тооцогдоно.

Өмнөговь аймгийн газар нутаг нь маш өргөн хүрээний бодит болон бодит бус соёлын өвийн үнэт зүйлстэй. Энэ бүс нутагт олон жил судалгаа хийсэн бөгөөд ихэнх судалгааг социализмын үед хийж гүйцэтгэсэн. 2002 оноос хойш Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнгээс Оюу Толгой компанийн захиалгаар соёлын өвийн үнэлгээг 40 удаа (археологийн 26, палеонтологийн 11, угсаатны зүйн 3) хийсэн нь энэхүү бүс нутгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулахад хувь нэмрээ оруулсан болно.

Оюу Толгой компанийн үйл ажиллагаа явуулдаг Өмнөговийн бүс нутгийн соёлын өвийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бусад эх сурвалжаас авч болох бөгөөд энд зөвхөн товчоор дурьдсан болно. Дэлгэрэнгүй мэдээллийг Монголын олон улсын соёлын өвийн багаас гаргасан 1-р шатны тайланг үзэнэ үү (Өнгөрснийг хамгаалж, өнөөдрийг хадгалах: Оюу Толгой төслөөс Өмнөговь аймагт хэрэгжүүлэх Соёлын өвийн хөтөлбөрийн 1-р шатны ажлын тайлан).

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан соёлын өвийн төрлүүд*Биет бус соёлын өв*

Монголын уламжлалт ахуй болон нүүдлийн хэв маягтай холбоотой биет бус онцгой ач холбогдолтой соёлын өвийн үнэт зүйлс их байдгийн дотор Өмнөговь аймгийн хэмжээний дуу хөгжим, гар урлал, хэл соёл, сүсэг бишрэл, итгэл үнэмшил, аман түүх болон Монгол бичиг байдаг. Биет бус үнэт зүйлс нь мөн бодит газар нутаг, эд зүйлстэй холбоотой байх нь бий. Үүнд газар нутгийн байгаль орчинтой холбоотой зүйлс багтах ба, тухайлбал уул (жишээ нь хадны бичээс ихтэй Жавхлант уул) болон хүний гараар бүтсэн зүйлс орно (жишээ нь овоо). Өмнийн говийн нутгаар домог, зан заншил, түүхтэй холбоотой ариун дагшин газруудыг олж тодорхойлсон байна. 1-р шатны тайланд дурьдсанаар биет бус соёлын өвийн үнэт зүйлс нь орон нутгийн ард иргэдэд онцгой ач холбогдолтой юм.

Биет соёлын өв

Биет соёлын өвд археологийн болон палеонтологийн олдворууд багтдаг. Археологийн олдворууд нь Палеолитийн (Чулуун зэвсгийн) үеэс эхлэн төмөр зэвсгийн үеүүд, хамгийн ойрын гэвэл энэ бүс нутгаар 1930-аад онд социалистуудын нураасан шарын шашны сүмүүдийн үлдэгдэл болно. Эдгээр үеүүд нь археологийн өргөн хүрээтэй олдворуудад Палеолитийн чулуун олдворууд бүхий талбай, дөрвөлжин булш, буган хөшөө, хадны зураг, суурин газар, булш, хөшөө болон шарын шашны сүм хийдийн тууриар илэрхийлэгддэг.

Өмнийн говийн бүс нутаг нь мөн эрт дээр үеийн байгаль орчин, цаг үеийн онцлогийг илэрхийлсэн үлэг гүрвэл болон чулуужсан модны палеонтологийн үнэт их өвтэй гэдгээрээ алдартай. Үлэг гүрвэлийн зарим олдвор нь олон улсад ач холбогдолтой бөгөөд үүний дотор үлэг гүрвэлийн мөр болон яс нэг дороос олдсон Шар Цав гэдэг газар багтдаг.

2.2 Бусад удирдлагын төлөвлөгөөтэй давхцах байдал

Энэхүү Удирдлагын төлөвлөгөө нь Оюу Толгой төсөлд зориулан боловсруулсан Үйл ажиллагааны удирдлагын цогц төлөвлөгөөний нэг хэсэг бөгөөд үүнийг *Байгаль орчин болон нийгмийн удирдлагын төлөвлөгөөний цогц баримт бичигт* (OT-10- PLN-0003) тодорхой оруулсан болно.

Энэхүү Удирдлагын төлөвлөгөө нь Удирдлагын бусад төлөвлөгөөтэй давхцсан, мөн харилцан уялдсан бөгөөд үүнд:

- Газар ашиглалтын удирдлагын төлөвлөгөө (OT-10-E9-PLN-0001), үүний дотор Газар хөндөх зөвшөөрлийн системийг хэрэгжүүлэхтэй уялдсан
- Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөө (OT-10-E10-PLN-0001), үүний дотор Бор Овоогийн булгийг шилжүүлэхтэй уялдсан;
- Оролцогч талуудтай харилцах төлөвлөгөө (OT-05-PLN-0001), үүний дотор орон нутгийн хэлэлцүүлгийн шаардлагатай уялдсан;
- Гэрээт компаниудын удирдлагын орчин (OT-07-PLN-9007), үүнд гэрээт компанийн соёлын өвийн удирдлагын төлөвлөгөөний шаардлагатай уялдсан;
- Хэт төвлөрлийг зохицуулах удирдлагын төлөвлөгөө (OT-10-PLN-0005), үүний дотор биет бус соёлын өв, амьдралын уламжлалт хэв маягтай уялдсан;
- Агаарын бохирдлын удирдлагын төлөвлөгөө (OT-10-E2-PLN-0001), үүний дотор тоосны хяналттай уялдсан; болон
- Хөдөлмөрийн удирдлагын төлөвлөгөө (OT-10-PLN-0005), үүнд Кэмгийн стандарт болон Ёс зүйн дүрэм (HR-ST-01).

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

3 ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

3.1 Удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийн үндсэн үүрэг хариуцлага

Энэ удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үндсэн хариуцагчид, тэдгээрийг үүргийг доор үзүүлэв.

Хүснэгт 1: Үндсэн үүрэг хариуцлага

Хариуцагч	Гүйцэтгэх үүрэг
Ерөнхий менежер	<ul style="list-style-type: none"> Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилт болон хэрэгжүүлэхэд шаардлагатай зохих эх үүсвэрүүдийг хувиарлах нийт хариуцлага. Удирдлагын хороотой харилцах.
Орон нутгийн харилцаа болон Соёлын өв хариуцсан менежер	<ul style="list-style-type: none"> Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөөний талаар бүрэн мэдлэгтэй байж, төлөвлөгөөг хэрэгжих эх үүсвэрээр хангах. Оюу Толгойн уурхайн талбай дээрх хариуцагч байх.
Төслийн менежерүүд	<ul style="list-style-type: none"> Оюу Толгойн Соёлын өвийн удирдлагын тогтолцоог ойлгож, мөрдөн ажиллах.
Соёлын өв хариуцсан ахлах ажилтан	<ul style="list-style-type: none"> Соёлын өвийн удирдлагын тогтолцоо (СӨУТ) болон энэхүү Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх; Соёлын өвийн (СӨ) үнэлгээг зохион байгуулах; Соёлын өвийн дурсгалт газрыг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах; Холбогдох төр засгийн байгууллага болон орон нутгийн талуудтай харилцаж соёлын өвийн зөвшөөрөл авах, хэлэлцүүлэг хийх ; Газар хөндөх зөвшөөрлийн (ГХЗ) соёлын өвийн бүрэлдэхүүн хэсгийг хариуцах ; Соёлын өвийн газар зүйн мэдээллийн системийн өгөдлийн сан ажиллаж буй эсэх, шинэчлэгдсэн эсэх, Оюу Толгойн үйл ажиллагаатай уялдаж буй эсэхийг хянах, тухайлбал, газар хөндөх зөвшөөрөл. Холбогдох зөвшөөрөлгүйгээр соёлын өвийн талбайг ажлын явцад эвдэхгүй байхад хяналт тавих Зөвшөөрөлгүйгээр талбайг хөндсөн, журам зөрчсөн тохиолдолд хяналт шалгалт хийж, тайлагнах, арга хэмжээ авах; Соёлын өвийн онцгой ач холбогдолтой болон эрсдэл өндөртэй талбаруудыг хянах хөтөлбөрийг Оюу Толгой компанийн зүгээс хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавих Соёлын өвийг хөндөж болзошгүй төслүүдэд оролцож буй ажилтнуудыг шаардлагатай сургалт, танилцуулгад хамруулж соёлын өвийн талаархи үүрэг хариуцлагыг ойлгуулах; Гэрээт гүйцэтгэгчийн удирдлага; Баримт бичгийн удирдлага; ба Хууль журам буюу бодлогын өөрчлөлтийн удирдлага.

Газар хөндөх зөвшөөрөлд төслийн менежерүүдэд соёлын өвийн асуудлыг ойлгоход туслах хуудас багтдах ба соёлын өвийн үнэлгээ, соёлын өвд тулгарч болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд Оюу Толгойн холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулах журмыг багтаасан болно.

Бүх ажиллагсад болон гэрээт ажилтнуудад соёлын өвийн талаарх ойлголт, мэдлэг олгох сургалт өгөгдөнө.

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

3.2 Гол уялдаа холбоо

Энэхүү Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үндсэн харилцаа дараахь албан тушаалтнуудад хамаарна (Удирдлагын төлөвлөгөөний үндсэн хэсгүүдийг хэрэгжүүлэх хариуцсан албан тушаалтан):

- Газар хөндөх зөвшөөрөлтэй уялдан Байгаль орчны менежер;
- Соёлын өвийн талаархи сургалттай холбоотойгоор Сургалтын менежер;
- Засгийн газартай харилцах менежер, үүнд Соёлын өвийн хөтөлбөрийн хүрээнд байгуулж буй Говийн соёлын өвийн судалгааны төв болон засгийн газартай харилцах;
- Хүний нөөцийн менежер, үүнд Оюу Толгойн Кэмпийн стандарт болон Ёс зүйн журмыг (HR-ST-01) хэрэгжүүлэхтэй холбоотойгоор; болон
- Тээвэр хариуцсан менежер, тээврийн хяналт тавихтай холбоотойгоор

4 ТӨСЛИЙН СТАНДАРТ

Төслийн бүхий л үйл ажиллагаанд холбогдох стандартуудыг (“Төслийн стандарт”) дагаж хэрэгжүүлнэ. Төслийн стандартууд доорх бүтэцтэй байна. Үүнд:

- Монгол улсын холбогдох хууль болон үндэсний стандартууд;
- Монгол улсын засгийн газрын өмнө хүлээсэн үүрэг амлалт, бусад шаардлагууд;
- Санхүүгийн зээлдүүлэгчийн стандартууд болон удирдамжууд;
- Рио Тинто болон Оюу Толгой компанийн холбогдох стандартууд;
- Оюу Толгойн зүгээс хэрэгжүүлж, мөрдөх зорилт тавьсан салбарын бусад удирдамжууд.

4.1 Монгол улсын холбогдох хууль болон үндэсний стандартууд

Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль нь 2001 оны 6-р сард батлагдсан (уг хуульд 2005 онд нэмэлт өөрчлөлт орсон).

Энэ хуулийн зорилт нь биет болон биет бус соёлын өвийг цуглуулах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж, хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах, өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Соёлын өвийн чухал ач холбогдол бүхий зүйл гэдэгт уурхайн зорилгоор ашиглаж байсан газрууд, булш хиргисүүр, бунхан, хөшөө чулуу, хадны сүг зураг, бичээс зэрэг археологийн олдвор багтана. Түүх, соёлын дурсгалт зүйлийг түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдлоор нь хосгүй үнэт, үнэт, ердийн гэж зэрэглэх ба эдгээрийг хамгаалах ажлыг үндэсний, бүсийн (аймгийн) болон орон нутгийн (сумын) түвшинд тогтоож өгсөн байдаг.

Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ямар соёлын өвийг ямар хэмжээнд хамгаалах тухай шийдвэр гаргадаг. Тус хуулиар, түүх, соёлын дурсгалт зүйлийг тухайн орон нутагт нь хадгалах зарчим баримтална. Үүнээс гадна соёлын болон түүхэн үнэ цэнэ бүхий газруудад хамгаалалтын бүс тогтоох эрхийг энэ хуулиар засгийн газарт олгожээ. Хамгаалагдсан бүст нөлөөлөл үүсгэж болох үйл ажиллагаа явуулахыг хориглодог.

Тус хуулийн 17 дугаар заалтаар ашигт малтмалын хайгуул, болон олборлолт явуулахаас өмнө мэргэжлийн зөвшөөрөгдсөн байгууллагаар түүх, археологийн урьдчилан хайгуул, судалгаа хийлгэнэ. Мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн болон уурхайн эрэл хайгуул, олборлолтын улмаас түүх соёлын өвд эрсдэл учирсан тохиолдолд орон нутгийн захиргаанд нэн даруй мэдэгдэж, уг газрыг хамгаалалтанд авахыг хуулиар шаарддаг. Тухайн сумын засаг дарга судалгаа хийсэн талбайг хариуцна. Түүхэн, шинжлэх ухааны болон соёлын

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

үнэ цэнэтэй зүйлс бүхий газрыг улсын хамгаалалтанд авдаг бөгөөд энд байгаа олдворууд бас улсын өмч юм.

2006 онд батлагдсан **Монгол улсын Ашигт малтмалын тухай хууль** (уг хуульд 2011 онд нэмэлт өөрчлөлт орсон).

Лиценз эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны улмаас түүх, соёлын дурсгалт газарт учруулсан хохирлыг бүрэн нөхөн төлнө.

Соёлын өвийг хамгаалах болон менежмент хийхтэй холбоотой Монгол улсын үндэсний стандарт байхгүй болно.

4.2 БОНБНУ-ийн шаардлагууд

Тус удирдлагын төлөвлөгөөнд БОНБНУ-нд багтан орсон Оюу Толгойн Байгаль орчин хамгаалах төлөвлөгөө болон Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан соёлын өвийн менежмент болон хяналт шинжилгээний шаардлагуудыг тусгасан болно.

4.3 Монгол улсын Засгийн газрын өмнө хүлээсэн бусад үүрэг амлалт, шаардлагууд

- Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенци (1975 он) (Монгол улс 1990 оны 2 сарын 2-нд нэгдэн орсон);
- Биет бус соёлын өвийн аюулгүй байдлыг хангах конвенци (2006 оны 4-р сарын 20-нд хүчин төгөлдөр болсон; Монгол улс 2005 оны 6 сарын 29-нд уг конвенцид нэгдэн орсон); ба
- ОУХДК-ийн удирдамж (Олон улсын Хөшөө дурсгалын комисс), Хөшөө дурсгалыг хадгалах болон нөхөн засварлах талаарх олон улсын дүрэм (Венийн чартер, 1964 он).

4.4 Зээлдүүлэгчийн стандарт болон удирдамжууд

- ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт 8 – Соёлын өв; ба
- ЕСБХБ-ны биет ба биет бус соёлын өвийн талаарх бодлого нь Гүйцэтгэлийн шаардлага 8 (ГШ8)-д тусгагдсан байдаг.

4.5 Рио Тинто болон Оюу Толгой компанийн холбогдох стандартууд

Рио Тинто компанийн *Орон нутгийн стандарт* (Хэсэг 1.6)¹ нь холбогдох орон нутагтай хамтран соёлын өвийн менежментийг хийх болон соёлын өвийн удирдлагын системийг боловсруулах болон хэрэгжүүлэх зэргийг оролцуулсан Рио Тинто группийн компаниудын соёлын өвийн менежментэнд тавигдах шаардлагыг тодорхойлсон болно.

Рио Тинто компанийн Соёлын өвийн удирдлагын удирдамжинд Рио Тинто компанийн Орон нутгийн стандартийг хэрхэн дагаж мөрдөх талаар дэлгэрэнгүй мэдээллийг тусгасан байгаа болно (Хэсэг 1.6).

¹ Рио Тинто компанийн Орон нутгийн стандарт болон соёлын өвийн удирдлагын удирдамжийг Рио Тинто компанийн цахим хуудсан дээр дараахь линкээр дамжуулан үзэж болно.
http://www.riotinto.com/library/3608_policies.asp

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

Оюу Толгой компани Рио Тинтотой зөвшилцөн боловсруулсан Оюу Толгойн Соёлын өвийн удирдлагын тогтолцооны (СӨУТ) журмын удирдамжийг энэ удирдлагын төлөвлөгөөний Хавсралт А-д багтаан оруулсан болно.

СӨУТ-н журмын удирдамжинд Оюу Толгойн Дурсгалт зүйл олдоход баримтлах журмыг тусгасан болно.

4.6 Төслийн холбогдох стандартуудын хураангуй

Оюу Толгой дотоодын стандартууд зээлдүүлэгчийн холбогдох стандартууд, Рио Тинто компанийн холбогдох стандартууд, мөн төслийн стандартуудаас хамгийн шаардлага өндөртэйг нь сонгон биелүүлж, мөрдөнө.

Төслийн холбогдох стандартуудыг доор хураангуйлан үзүүлэв.

Хүснэгт 2: Төслийн холбогдох стандарт

Төслийн стандарт	Шаардлага
Монгол улсын Соёлын хамгаалах хууль	<ul style="list-style-type: none"> • Ашигт малтмалын хайгуул хийх, уурхайн бүтээн байгуулалт зэрэг үйл ажиллагаа эхлэхээс өмнө мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагаар түүх, археологийн урьдчилан хайгуул, судалгаа хийлгэнэ. • Мэргэжлийн археологийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж болохгүй. • Соёлын дурсгалт зүйл илэрсэн болон эрсдэл учирсан тохиолдолд энэ тухай сум, дүүргийн Засаг даргад нэн даруй мэдэгдэж, уг газрыг хамгаалалтанд авна. • Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны зөвшөөрөлгүйгээр соёлын болон өвийн ач холбогдолтой үл хөдлөх соёлын өвийг ухах, шилжүүлэх, устгахыг хориглоно.
Монгол улсын Ашигт малтмалын хууль	Лиценз эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны улмаас түүх, соёлын дурсгалт газарт учруулсан хохирлыг тэдгээрийн өмчлөгч болон эзэмшигч этгээдэд бүрэн нөхөн төлнө.
БОНБНУ	Хамгаалалтын торон хашаа, Дурсгалт зүйлс олдоход баримтлах журам, гэрээт гүйцэтгэгчдэд СӨ болон Дурсгалт зүйлс олдоход баримтлах журмын талаар мэдлэг, мэдээлэл олгох сургалт зэргийг хэрэгжүүлэх.
Дэлхийн конвенци	<p>Монгол улсын Засгийн газар Дэлхийн өвийн конвенцид нэгдэн орсон билээ. Хэдийгээр энэ нь Оюу Толгойд шууд хамаарахгүй ч гэсэн, тус конвенцийн зарчмууд Монгол улсад СӨ-ийн хууль болон бодлогоор дамжуулан хэрэгжиж байгаа болно.</p> <p>Тус конвенцид нэгдэн орсон улс учир, Монгол улсын засгийн газар өөрийн нутаг дэвсгэр дээрх Дэлхийн өвийн газар болон өөрийн дотоодын хамгаалалтад авсан өвийг хадгалах үүрэг хүлээсэн билээ. Тухайн улс нь соёлын болон байгалийн өвийн хамгаалалтыг бүс нутгийн төлөвлөлтийн хөтөлбөрт тусгах, эдгээр өвийг хамгаалах ажилтнууд болон үйлчилгээг бий болгох, шинжлэх ухааны болон техникийн хадгалан хамгаалах судалгааг хийж, орон нутгийн иргэдийн өдөр тутмын амьдралд энэ өв соёлыг тусгах чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг дэмждэг.</p>
Биет бус өвийн байдлыг конвенци	<p>Монгол улсын засгийн газар нь Биет бус соёлын өвийн аюулгүй байдлыг хангах конвенцид нэгдэн орсон билээ. Хэдийгээр энэ нь Оюу Толгойд шууд хамаарахгүй ч гэсэн, тус конвенцийн зарчмууд Монгол улсад СӨ-ийн хууль болон бодлогоор дамжуулан хэрэгжиж байгаа болно.</p> <p>Тус конвенцид нэгдэн орсон учир, Монгол улсын засгийн газар өөрийн нутаг дэвсгэр дэхь биет бус соёлын өвийг дараахь байдлаар хамгаалахаар зөвшөөрсөн болно. Үүнд i) өөрийн нутаг дэвсгэр дэхь биет бус СӨ-ийн янз бүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодруулж, эдгээрийг хамгаалах бүрэн чадавхитай байгууллагыг тохоон томилох ii) биет бус СӨ-тэй харьцах, баримтжуулах, ашиглах боломжийг бий болгох</p>

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

Төслийн стандарт	Шаардлага
	зохих хууль эрхзүйн, санхүүгийн болон бусад арга хэмжээг боловсруулах зэрэг орно.
ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт 8 – Соёлын Өв.	<ul style="list-style-type: none"> • Төслийн төлөвлөлт хийхдээ соёлын өвд ноцтой хохирол учруулахаас зайлсхийх. • СӨ-ийн ач холбогдолыг тодорхойлох болон энэ талаар орон нутгийн иргэдийн санал бодлыг шийдвэр гаргах үйл явцад тусгах зорилгоор тухайн орон нутгийн иргэд болон холбогдох захиргааны байгууллагуудтай хэлэлцүүлэг хийнэ. • Төслийн зүгээс Дурсгалт зүйлс олдоход баримтлах журмыг боловсруулж, хэрэгжүүлэх. • ‘Чухал соёлын өвийг’ ихээхэн өөрчилж, гэмтээж, зайлуулж болохгүй. • Хэрвээ төсөл орон нутгийн биет бус соёлын өвийг арилжааны зорилгоор ашиглах бол орон нутагтай зөвшилцөх, зөвшөөрөл авах, хүртэх ашиг тусыг тогтооно.
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн стандарт 8 – Соёлын Өв.	<p>Гүйцэтгэлийн стандарт 8-ын зорилго:</p> <ul style="list-style-type: none"> • ЕСБХБ-ны хөрөнгө оруулалттай төслүүд дээр соёлын өвийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх • Төслийн үйл ажиллагаанаас үүдэн соёлын өвд үзүүлж болзошгүй аливаа сөрөг нөлөөллөөс хамгаалах • Соёлын өвөөс хүртэх ашиг шимийг жигд хуваарилахад туслах • Соёлын өвийн тухай ойлголт мэдлэгийг дээшлүүлж, түүнд хүндэтгэлтэй хандахыг дэмжих
Рио Тинто компаний Орон нутгийн стандарт	<p>“Соёлын өвийг холбогдох орон нутагтай хэлэлцүүлэг хийсний үндсэн дээр шийднэ. Үүний тулд бүх бизнесүүд доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:</p> <p>a. Холбогдох соёлын хэм хэмжээнд биет соёлын өвийн жагсаалт болон биет бус соёлын өвийн үнэ цэнийн ойлголтыг тогтоох;</p> <p>b. Тухайн бизнесийн өөрийн бүх аж үйлдвэрлэлийн болон түүхэн өвийг баримтжуулах;</p> <p>c. Группийн удирдамжид нийцсэн соёлын өвийн удирдлагын системийг боловсруулж, хэрэгжүүлэх;</p> <p>d. Сэргээн засварлах боломжгүй соёлын өвийг аль болохоор гэмтээхгүй байхаар үйл ажиллагаагаа төлөвлөх;</p> <p>e. Соёлын өвийг хөндөхөөс зайлсхийх аргагүй бол тухайн соёлын өвд хамааратай оролцогч талуудаас хууль ёсны дагуу зөвшөөрөл авах;</p> <p>f. Соёлын өвийг хөндсөн аливаа томоохон зөрчлийн талаар Орон нутгийн үйл ажиллагааны ахлагчид (хэсэг 2.9-т дурдсаны дагуу) нэн даруй мэдээлэх;</p> <p>g. Соёлын өвийг хамгаалах талаар холбогдох орон нутагтай хамтран ажиллах;</p> <p>h. Орон нутгийн соёлын хэм хэмжээнд гарч байгаа өөрчлөлт бизнесийн үйл ажиллагаанаас болсон эсэхийг орон нутгийн хэлэлцүүлэгийн хүрээнд хэлэлцэх;</p> <p>i. Уугуул иргэдтэй тэдний хууль ёсны эрх болон ашиг сонирхол нь хөндөгдөх асуудлаар аливаа хэлэлцээр хийхдээ соёлын өвийн асуудлыг тусгах.”</p>

Соёлын өвийн удирдлагын тогтолцоо

Оюу Толгой компани Рио Тинто компанитай хамтран Группийн хэмжээний удирдамжийг биелүүлэх үүднээс Соёлын өвийн удирдлагын тогтолцоог (СӨУТ) боловсруулсан. СӨУТ нь соёлын өвийг хамгаалах болон менежментийг хэрэгжүүлэх багц журам, үйл ажиллагаанаас бүрдэх бөгөөд Оюу Толгойд соёлын өвийн удирдлагын үүрэг зорилтоо биелүүлэх боломжийг олгоно. Эдгээр үйл ажиллагаа болон журмыг Оюу Толгойн СӨУТ-ын журмын удирдамжинд тусгасан болно (энэ удирдлагын төлөвлөгөөний Хавсралт А –д үзүүлсэн болно). Энэ журам нь Монголын Олон Улсын Өвийн багийн (МОУӨБ) боловсруулсан *Оюу Толгойн Соёлын Өвийн Хөтөлбөрийн* тайланд дурдсан аргачлал, зөвлөмжийг мөн тусгасан болно.

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

СӨУТ-ийн үндсэн үйл ажиллагаа болон журамд дараах зүйлс багтана. Үүнд:

- Орон нутгийн иргэдтэй хийх хэлэлцүүлэг;
- Газар хөндөх зөвшөөрөл;
- Соёлын өвийн үнэлгээ;
- Соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө;
- Соёлын өвийн удирдлага болон нөлөөлөл бууруулах арга хэмжээ;
- Сургалт болон зааварчилга;
- Мэдээлэл болон өгөгдлийн удирдлага (СӨ-ийн GIS буюу газарзүйн мэдээлэлийн системийг оролцуулан); ба
- Хяналт шинжилгээний болон осол зөрчлийн удирдлагын үйл ажиллагаа (Дурсгалт зүйлс олдоход баримтлах журмыг багтаасан).

Соёлын өвийн хөтөлбөр

Оюу Толгойн Соёлын өвийн хөтөлбөрийн тайланд (СӨХ – өмнө нь СӨХ-ийн 2-р үе шат гэж бас нэрлэж байсан) Өмнийн говийн соёлын өвийг хамгаалах урт удаан хугацааны стратегийг тусгасан болно. Үүнд Оюу Толгойн шууд нөлөөллийн бүс (ШНБ) болон шууд бус нөлөөллийн бүсийн (ШБНБ) биет болон биет бус өвийг хамгаалах ажлууд болон хөтөлбөрүүд орно. СӨХ-ийн тайланд дурдсанчлан, СӨХ-ийн хэрэгжилт Монгол улсын Шинжлэх ухааны академийн (МШУА) хүрээнд шинээр Говийн соёлын өвийн судалгааны төвийг (ГСӨСТ) байгуулахад тулгуурлана. Тус төв нь соёлын өвийг хамгаалах урт хугацааны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхийн тулд аймаг, сумдууд, Оюу Толгой болон бусад холбогдогч талуудтай хамтран ажиллана.

Энэхүү ашиглалтын шатны удирдлагын төлөвлөгөөний нэг хэсэг болох тус СӨХ-ийг хэрэгжүүлэхдээ дараах зүйлсийг онцлон авч үзнэ. Үүнд:

1) Монголын олон улсын өвийн баг, МШУА, Өмнөговь аймгийн болон сумын засаг захиргаа, байгууллага болон бусад холбогдогч талуудтай ГСӨСТ-г байгуулах (Хүснэгт 3 дээр жагсаасны дагуу) талаар хамтран ажиллах; ба

2) ГСӨСТ-г байгуулах хүртэлх шилжилтийн хугацаанд СӨХ-ийн хүрээнд тусгасан эн тэргүүний зорилтуудтай нийцүүлэн соёлын өвийг хамгаалах тодорхой хөтөлбөрийг холбогдогч талуудтай хамтран хэрэгжүүлэх.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

5 УДИРДЛАГЫН ХЯНАЛТУУД

Оюу Толгой төслийн БОННУ-ийн хүрээнд тодруулсан эрсдэл болон нөлөөллийг зохицуулах зорилгоор олон төрлийн удирдлагын хяналтыг боловсруулсан бөгөөд дээр нь Рио Тинто компаний Орон нутгийн стандартын хүрээнд удирдлагын хяналтуудыг боловсруулсан болно. Удирдлагын үндсэн хяналтыг холбогдох бичиг баримтын хамт доор үзүүлэв.

Хүснэгт 3: Удирдлагын үндсэн хяналтууд

№	Сэдэв/ Талууд	Хэрэглээ/ Үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцах тал	Баталгаажуулалт
СН01.1	СӨ дурсгалт газар/эд зүйлс алдагдах	Уурхайн талбай, дэд бүтэц + өөр бусад Оюу Толгойн лицензит талбай Гуравдагч этгээдийн эзэмшлийн газар дээрх Оюу Толгойн үйл ажиллагаа	Газар хөндөх зөвшөөрлийн СӨ-ийн бүрэлдэхүүн хэсгийг багтаасан Оюу Толгойн СӨУТ-ийн журмыг хэрэгжүүлэх.	Бүсийн хөгжил, нийгмийн харилцаа ЭМААБО Барилгын ажлын өргөжилт ЭМААБО Геологи	СӨУТ-ийн аудит + үзлэг шалгалтын хөтөлбөр СӨМС-ийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн тайлангууд Газар хөндөх зөвшөөрлийн аудит
СН01.2	СӨ дурсгалт газар/эд зүйлс алдагдах	Барилгын болон ашиглалтын шатны үйл ажиллагаа	Оюу Толгойн ажилчид болон гэрээт гүйцэтгэгч нарт соёлын өвийн болон дурсгалт зүйлс олдоход баримтлах журмыг танилцуулах.	Сургалт Бүсийн хөгжил, нийгмийн харилцаа	Сургалтын материал Сургалтын бүртгэл
СН01.3	СӨ дурсгалт газар/эд зүйлс алдагдах	Уурхайн лицензит талбай	Оюу толгойн СӨУТ-г хэрэгжүүлэх. Хуулбар загварыг тохиромжтой газар байрлуулан нийтэд танилцуулах	Бүсийн хөгжил, нийгмийн харилцаа <i>Монголын олон улсын соёлын өвийн баг</i> <i>Орон нутгийн захиргаа+ бусад оролцогч талууд</i>	Аудит + үзлэг шалгалтын хөтөлбөр

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

№	Сэдэв/ Талууд	Хэрэглээ/ Үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцах тал	Баталгаажуулалт
СН01.4	СӨ дурсгалт газар/эд зүйлс алдагдах	Уурхайн лицензит талбай – Бор Овоог шилжүүлэх	Бор Овоогийн булгийг орлуулах шинэ булгийг Ундай голд байгуулахтай холбоотойгоор Бор Овоогийн соёлын өвийн байршлыг шилжүүлэх . <i>W02.1, Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөө</i>	ЭМААБО Бүсийн хөгжил, нийгмийн харилцаа	Аудит + үзлэг шалгалтын хөтөлбөр
СН02.1	СӨ-ийн дурсгалт газар/эд зүйлсэд шууд бус нөлөөлөл учрах	Ашиглалт /Төслийн үйл ажиллагаа	Оюу Толгойн СӨУТ-н журмыг хэрэгжүүлэх (эрсдэл өндөртэй соёлын өвийн дурсгалт газруудад хамгаалалт байршуулах болон хяналт шинжилгээ хийх зэрэг (хил тогтоох, хашаалах, тэмдэглэгээ хийх))	Бүсийн хөгжил, нийгмийн харилцаа	Аудит + үзлэг шалгалтын хөтөлбөр СӨУТ-н хяналт шинжилгээний хөтөлбөр
СН02.2	СӨ-ийн дурсгалт газар /эд зүйлсэд шууд бус нөлөөлөл учрах Биет бус өвд учрах нөлөөлөл	Ашиглалт /Төслийн үйл ажиллагаа	Монголын олон улсын өвийн баг, үндэсний болон орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн байгууллага болон бусад оролцогч талуудтай хамтран, ялангуяа олон нийтийн хөтөлбөрүүд дээр хамтран ажиллаж СӨХ-ийг хэрэгжүүлэх.	Бүсийн хөгжил, нийгмийн харилцаа <i>Монголын олон улсын соёлын өвийн баг</i> Үндэсний + орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн байгууллага + бусад оролцогч талууд	Аудитын хөтөлбөр – харилцаа холбоо, хөтөлбөрийн тайлан
СН03.1	СӨ-ийн дурсгалт газар / эд зүйлийг зориуд эвдэх, гутаан доромжлох	Ашиглалт /Төслийн үйл ажиллагаа	Оюу Толгойн ажилчид болон гэрээт гүйцэтгэгчдэд соёлын өвийн талаарх мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулах.	Хүний нөөц Бүсийн хөгжил, нийгмийн харилцаа	Сургалтын материал Сургалтын бүртгэл
СН03.2	СӨ-ийн дурсгалт газар/ эд зүйлийг зориуд эвдэх, гутаан доромжлох	Ашиглалт /Төслийн үйл ажиллагаа	Оюу Толгойн СӨХ-ийн хүрээнд уламжлалт ариун дагшин газрууд болон холбогдох соёлын уламжлал, биеэ авч явах байдлын хэм хэмжээ зэргийн талаар тодруулж, хамгаалах.	Бүсийн хөгжил, нийгмийн гүйцэтгэл <i>Монголын олон улсын соёлын өвийн баг</i> Үндэсний + орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн байгууллага +	Аудитын хөтөлбөр - тайлан + бүтээмж

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

№	Сэдэв/ Талууд	Хэрэглээ/ ажиллагаа	Үйл	Хяналтын тодорхойлолт	Хариуцах тал	Баталгаажуулалт
					<i>бусад оролцогч талууд</i>	
СН03.3	СӨ-ийн дурсгалт газар/ эд зүйлийг зориуд эвдэх, гутаан доромжлох	Ашиглалт /Төслийн ажиллагаа	үйл	Оролцогч талуудтай харилцах төлөвлөгөөнд талчид, орон нутаг болон бусад оролцогч талуудтай ГХЗ, дурсгалт газар тогтоох болон хяналт шинжилгээ, осол зөрчлийн талаар хэлэлцэх журмыг тусгах.	Бүсийн хөгжил, нийгмийн харилцаа	Аудит болон үзлэг шалгалтын хөтөлбөр
СН04.1	Биет бус өвд учирч болзошгүй нөлөөлөл			Оюу Толгойн шууд нөлөөллийн бүс (ШНБ) болон шууд бус нөлөөллийн бүсийн (ШБНБ) бусад сумдын соёлын арга хэмжээ болон баяр наадмыг (жил бүр) дэмжих.	Бүсийн хөгжил, нийгмийн харилцаа	Аудитын хөтөлбөр - Санхүүжилтийн хүсэлт болон төлбөрийн бүртгэл
СН04.2	Биет бус өвд учирч болзошгүй нөлөөлөл			Ханбогд сумын музейн өргөтгөлийг барих, санхүүгийн дэмжлэг үзүүлэх.	Бүсийн хөгжил, нийгмийн харилцаа Сумд <i>Монголын олон улсын соёлын өвийн баг</i> <i>Үндэсний + орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн байгууллага</i>	Аудитын хөтөлбөр - Талуудын оролцооны бүртгэл, Төлөвлөгөө, санхүүжилтийн бүртгэл Өргөтгөлийг барьж дууссан байх

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

6 ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ

6.1 Удирдлагын төлөвлөгөөний хяналт шинэчлэлт

Энэ удирдлагын төлөвлөгөөг жил бүр хянаж үзнэ. Өөрчлөгдөж буй нөхцөл байдал болон Оюу Толгойн үйл ажиллагааны эрэлт хэрэгцээнд тулгуурлан холбогдох өөрчлөлтийг хийж байна. Энэ удирдлагын төлөвлөгөөг хянах, шинэчлэх үүрэг хариуцлагыг энэ төлөвлөгөөг хариуцсан ажилтан буюу Оюу Толгойн Бүсийн хөгжил болон нийгмийн харилцааны ерөнхий менежер хүлээнэ.

Үйл ажиллагааны журманд тодорхой өөрчлөлт хийх шаардлагатай бол (Оюу Толгойн ЭМААБО-ын удирдлагын системн Өөрчлөлтийн удирдлагын журмын дагуу тодруулсан байна) энэ удирдлагын төлөвлөгөөг “ шаардлагын дагуу” гэсэн үндэслэлээр өөрчлөнө.

6.2 Хэрэгжүүлэх гол үе шатууд

Энэ удирдлагын төлөвлөгөөтэй холбоотой хэрэгжилтийн үндсэн хуваарийг доор харуулав.

Хүснэгт 4: Хэрэгжүүлэх гол үе шатууд

Үйл ажиллагаа	Зорилтот хугацаа
Оюу Толгойн СӨУТ-н журмын удирдамжийг эцэслэн боловсруулах	2012 оны сүүлээр
Оюу Толгойн СӨУТ-н журмын удирдамжийг боловсруулан+ хэрэгжүүлэх	2013 оны 2 дугаар сар
Оюу Толгойн СӨУТ-г бүрэн хэрэгжүүлэх	2013 оны сүүлээр
СӨУТ-н хэрэгжилт – санал болгосон төвийг байгуулах <ul style="list-style-type: none"> Зөвлөх хороог дахин эхлүүлэх Холбогдогч талуудын уулзалт Говийн СӨ-н судалгааны төвийн талаарх ТЭЗҮ-ийн судалгаа Монгол улсын Шинжлэх ухааны академи Говийн СӨ-н судалгааны төвийг байгуулах 	2013 оны 2 дугаар сар 2013 оны 4 дүгээр сар 2013 оны 8 дугаар сар 2014 оны 4 дүгээр сар (үргэлжлэх)
СӨУТ-н хэрэгжилт – төслийг үргэлжлүүлэх <ul style="list-style-type: none"> Оюу Толгойн шууд нөлөөллийн бүс (ШНБ) дэхь СӨ-н чухал байршлуудын СӨУТ-г боловсруулах Сумын соёлын төв + музей + бусад ажилтнуудад зориулсан чадавхийг хөгжүүлэх сургалт Сумын соёлын өвийн чиглэлийн төслүүд МШУА-н СӨ-н баримтжуулалт, хэвлэгдсэн материал, удирдлагын төслүүд 	2013 оны 5 дугаар сар 2013 оны 6 дугаар сар Үргэлжлэн явагдаж байгаа Үргэлжлэн явагдаж байгаа
Ханбогд сумын музейн барилгын өргөтгөл	2013 оны 12 дугаар сар (үргэлжлэх)

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

7 МОНИТОРИНГ

7.1 Мониторингийн шаардлагуудын тойм

Ашиглалтын үе шатанд төслийн стандартуудыг хэрхэн даган мөрдөж байгааг үнэлэх хяналт шинжилгээний арга хэмжээг энэ хэсэгт (Хэсэг 4: Төслийн стандартууд-г үзнэ үү) дурдав.

Хяналт шинжилгээний явцад төслийн стандартуудыг дагаж мөрдөөгүй тохиолдлыг илрүүлэх бол, эдгээрийг шалгаж, холбогдох засаж сайжруулах арга хэмжээг тодруулна (Оюу Толгойн СӨУТ-н Хэсэг 4 болон Оюу Толгойн Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдлагын системийг үзнэ үү).

7.2 Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд

Хүснэгт 5: Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд

№	ГГЗ	Зорилт	Хяналт шинжилгээний арга хэмжээ
СН-KPI 01	Энэ байгаль орчны удирдлагын төлөвлөгөөнд тусгасан удирдлагын үндсэн хяналтуудыг зөрчсөн тохиолдлын тайлан	• Бүртгэгдсэн зөрчлийн тоог хамгийн бага хэмжээнд бууруулах, тэглэх.	• Газар хөндөх зөвшөөрлийн журмын бүртгэлийг хянаж, судлах • СӨУТ-н аудит болон хяналт шинжилгээний тайланг хянаж, судлах
СН-KPI 02	Оюу толгойн СӨУТ-д тусгасан удирдлагын үндсэн хяналтын хэрэгжилтын тайлан	• СӨУТ-г хэрэгжүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгосон байх..	• Бүртгэл болон СӨУТ-н аудитыг хянах
СН-KPI 03	Соёлын өвийн дурсгалт газрыг хамгаалах төлөвлөгөөнд (СӨДГХТ) тусгасан удирдлагын үндсэн хяналтыг зөрчсөн тохиолдлуудыг мэдээлэх	• Соёлын өвийн дурсгалт газрыг хамгаалах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх. Бүртгэгдсэн зөрчлийн тоог хамгийн бага хэмжээнд бууруулах, тэглэх.	• Бүртгэл болон СӨУТ-н аудитыг хянах
СН-KPI 04	Соёлын өвийн танилцуулга болон сургалтанд суусан ажилтнуудын тоо	• Соёлын өвийн талаар мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг боловсруулж, Оюу Толгой төслийн бүх ажилчид болон 1-р ангилаллын гэрээт гүйцэтгэгч нар ажил эхэлснээс хойш зургаан сарын дотор энэ сургалтанд хамрагдсан байх. • Уламжлалт ариун дагшин газрууд болон амьд биет өвийн газруудтай холбоотой зөрчил тэг байх.	• Сургалтын бүртгэлийг хянаж, судлах • Соёлын өвийн бүртгэл болон гомдолын бүртгэлийг хянаж, судлах
СН-KPI 05	Биет бус СӨ-г баримтжуулах	• СӨХ-н хүрээнд биет бус СӨ-г баримтжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх.	• СӨХ-н хэрэгжилтийг хянах
СН-KPI 06	Биет бус СӨ-н хамгаалах хөтөлбөрийн хэрэгжилт	• Биет бус соёлын өвийг Оюу Толгойн ажилчдын болон гэрээт гүйцэтгэгчдийн	• СӨХ-н хэрэгжилтийг хянах

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

№	ГГЗ	Зорилт	Хяналт шинжилгээний арга хэмжээ
		<p>сургалтанд тусгах.</p> <ul style="list-style-type: none"> • Биет бус соёлын өвийг хадгалан авч үлдэхийн тулд СӨХ-н хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлэх. • Жил бүрийн баяр наадмыг дэмжих. • Ханбогд сумын музейг өргөтгөлийн барилгын ажлыг дэмжсэн байх. 	
СН-КР1 07	Орон нутгийн иргэдээс хүлээн авсан соёлын өвтэй холбоотой гомдлын тоо	<ul style="list-style-type: none"> • Соёлын өвтэй холбоотой аливаа гомдлыг (эд өлгийн зүйлсийг гутаан доромжлох, эвдэх, зайлуулах, тээвэрлэх г.м) магадлан шинжилж, зохих арга хэмжээг авах. • Ажилтнуудын соёлын өвийн зүй бус үйлдэлтэй холбоотой орон нутгаас хүлээн авсан аливаа гомдолд түргэн шуурхай арга хэмжээ авах. Оюу Толгойн гомдол барагдуулах журмын хүрээнд магадлан шинжилж, зохих арга хэмжээг авах. 	<ul style="list-style-type: none"> • Гомдлын мэдээллийн санг хянах

7.3 Мониторингийн гол үйл ажиллагаа

Мониторингийн үндсэн үйл ажиллагаа нь доор Хүснэгт 6-д дурдсан сэдэв болон аргачлалд чиглэнэ. Үүнд:

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

Хүснэгт 6: Мониторингийн гол үйл ажиллагаа

№	Сэдэв/Талууд	Аргачлал	Давтамж	Байршил
СНм01	Газар хөндөх зөвшөөрлийн журманд тусгасан СӨ-н шаардлагыг хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> • Газар хөндөх зөвшөөрөлд гарын үсэг зурж, баталгаажуулахдаа СӨ-н зөвлөмжийг заавал тусгах • Зөвшөөрлийн эх хувийг Оюу Толгойн Байгаль орчны хэлтэс хадгалах. • Газар хөндөх зөвшөөрөл авсан газар бүрийг ажил дууссанаас хойш 6 сарын дотор Газар хөндөх зөвшөөрлийн СӨ-н шаардлагатай нийцэж байгаа эсэхийг шалгаж байна. • Газар хөндөх зөвшөөрөл / төсөл бүр дээр Дурсгалт зүйлс олдоход баримтлах журмыг хэрэгжүүлэх. • Бүсийн хөгжил, нийгмийн харилцааны хэлтсийн баримт бичгийн хавтсанд Тохиолдлын олдворын тайлангийн бодит хувийг хадгалах. 	Барилгын шатанд зургаан сар тутам, дараа нь жил тутам	Газар хөндөх зөвшөөрөл шаардлагатай бүх барилгын болон ашиглалтын үйл ажиллагаанд
СНм02	СӨ-н сургалт	<ul style="list-style-type: none"> • “Дурсгалт зүйлс олдоход баримтлах” журмын талаар сургалтанд хамрагдсан Оюу Толгой төслийн ажилчид болон гэрээт гүйцэтгэгчдийн тоо 	Барилгын шатанд зургаан сар тутам, дараа нь жил тутам	Оюу Толгойн уурхайн талбар
СНм03	СӨ-тэй холбоотой зөрчил	<ul style="list-style-type: none"> • Хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд мэдээлэгдсэн зөрчлийн тоо. • Бүх зөрчлийг магадлан шинжилж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нөлөөлөл бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, гарын үсэг зурсан байх. • Бүсийн хөгжил болон нийгмийн харилцааны хэлтэс зөрчлийн мэдээллийн эх хувийг хадгалах. 	Барилгын шатанд зургаан сар тутам, дараа нь жил тутам	Төслийн талбай даяар
СНм04	СӨ-н дурсгалт газар/эд зүйлсэд шууд бусаар нөлөөлөл учрах	<ul style="list-style-type: none"> • Төслийн үйл ажиллагаа явагдаж буй талбай дээрх Соёлын өвийн дурсгалт газрыг хамгаалах төлөвлөгөөг (СӨДГХТ) боловсруулж, хэрэгжүүлэх. • Бүсийн хөгжил, нийгмийн харилцааны хэлтэс СӨДГХТ-ны мэдээллийн эх хувийг хадгалах. • Бүх эрсдэлд учирсан болон чухал соёлын өвийн дурсгалт газруудад Оюу Толгойн СӨДГХТ-н Соёлын өвийн удирдлагын хяналт шинжилгээний хөтөлбөр болон холбогдох журмын хүрээнд албан ёсоор хяналт шинжилгээ хийнэ. 	Барилгын хугацаанд зургаан сар тутам, дараа нь жил тутам	Бүх СӨ-н дурсгалт газар

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

		<ul style="list-style-type: none"> Бүсийн хөгжил, нийгмийн харилцааны хэлтэс хяналт шинжилгээний мэдээллийн эх хувийг хадгалах. 		
СНм05	СӨ-ийн дурсгалт газар / эд зүйлийг зориуд эвдэх, гутаан доромжлох	<ul style="list-style-type: none"> Соёлын өвийн зааварчилгаа сургалтанд хамрагдсан төслийн ажилчид болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилчдын тоо. Хүлээн авсан гомдлын тоо. Бүртгэсэн, хариу арга хэмжээ авсан болон барагдуулсан гомдол. 	Барилгын шатанд зургаан сар тутам, дараа нь жил тутам	Бүх СӨ-н дурсгалт газар
СНм06	Биет бус өвд нөлөөлөл учрах	<ul style="list-style-type: none"> Соёлын өвийн талаарх олон нийтийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх. 	Жил тутам	Төслийн талбай даяар

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

8 СУРГАЛТ

8.1 Тойм

Шаардлагатай бүх сургалтыг ерөнхий зааварчилгааны (ерөнхий мэдээлэл өгөх) хүрээнд өгөх бөгөөд шаардлагатай бол, тухайн ажлын байранд зориулсан тусгай сургалт зохион байгуулна.

8.2 Танилцуулга сургалт

Соёлын өвийн талаар мэдээлэл өгөх сургалтыг дараахь сургалт, зааварчилгын хүрээнд өгнө. Үүнд:

- Зочдод зориулсан танилцуулга сургалт;
- Оюу Толгойн ажилчид болон гэрээт гүйцэтгэгчдэд зориулсан ажлын талбайн ерөнхий зааварчилгаа;
- Оюу Толгойн ажилчид болон гэрээт гүйцэтгэгчдэд зориулсан “Шинэ ажилчдад зориулсан багц зааварчилгаа”.

Оюу Толгойн ажилчид болон гэрээт гүйцэтгэгчдэд зориулсан “шинэ ажилчдад зориулсан” багц зааварчилгаанд Дурсгалт зүйлс олдоход баримтлах журмын талаарх оруулсан байна.

Оюу Толгойн уурхайн талбайн ажилчид болон Ангилал 1-ийн гэрээт гүйцэтгэгчдэд Соёлын өвийн сургалтыг зохион байгуулна.

8.3 Ажлын байранд зориулсан тусгай сургалт

Тухайн ажлын байранд зориулсан соёлын өвийн тусгай сургалт зохион байгуулах шаардлагыг гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг харгалзан тогтооно. Тусгай сургалтын бүтцийг жил бүр шинэчлэн гаргана.

Ажлын байранд зориулсан сургалтанд дараахь орно. Үүнд:

- СӨУТ-н хүрээнд хариуцлага хүлээсэн, тодорхой үүрэг хариуцлага бүхий хүмүүст СӨУТ-н сургалт зохион байгуулах;
- Газар хөндөх зөвшөөрөл болон Соёлын өвийн дурсгалт газрыг хамгаалах төлөвлөгөөтэй холбоотой үйл ажиллагаанд зориулсан зааварчилгаа хийх;
- Холбогдох Оюу Толгойн ажилтнууд болон гэрээт гүйцэтгэгчдэд (газар шороо ухагч, зөөгч машин техникийг ажиллуулдаг ажилтнууд г.м) зориулсан “Дурсгалт зүйлс олдоход баримтлах” журмын талаарх сургалт зохион байгуулах;
- Оюу Толгойн “Проспект” портал хуудсанд соёлын өвийн осол зөрчлийг тайлагнах болон магадлан шинжлэхтэй тухай тусган оруулах.

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

9 АУДИТ БОЛОН ТАЙЛАН

9.1 Дотоод аудит

Ашиглалтын хүрээнд тухайн талбай хариуцсан ахлах ажилтнууд энэхүү соёлын өвийн удирдлага тэр дундаа “Дурсгалт зүйлс олдоход баримтлах” журмын хэрэгжилтэд өдөр тутмын хяналт тавина.

Хяналтын явцад илэрсэн аливаа зөрчлийг зөрчлийн удирдлагын системд бүртгэнэ. (Элемент 14)

Энэ төлөвлөгөөг хэрэгжүүлж, биелүүлж байгаа эсэхэд Элемент 16 Гүйцэтгэлийн Үнэлгээний дагуу жил бүр дотоодын аудит хийж хяналт тавина. Энэ нь ОТ ЭМААБО-ны Удирдлагын Систем (БОННУ болон удирдлагын төлөвлөгөөнүүд) -ийн нийт шаардлагуудын хэрэгжилтийг үнэлэх ажлын хүрээнд хийгдэнэ.

Эдгээр хяналт шалгалтын явцад илэрсэн аливаа зөрчлийг БОМТ-д дурьдсан ОТ ЭМААБО-ны Удирдлагын Системийн шаардлагын дагуу бүртгэнэ.

9.2 Хөндлөнгийн аудит

Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийг Рио Тинтогийн бизнес нэгжүүдийн ЭМААБО-ны гүйцэтгэлийн аудит болон Төслийн санхүүжүүлэгчдийн аудитын хөтөлбөрийн хүрээнд тогтмол шалгаж, үнэлж байна.

9.3 Бүртгэл хөтлөлт

Аудит, хяналт шалгалт, илэрсэн зөрчлүүдийг Элемент 8 Баримтжуулалт, Бичиг хэргийн бүртгэл болон Элемент 15 Мэдээлэл бүртгэлийн удирдлагын дагуу зохицуулна.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: RD-10-PLN-0002-M	Хувилбар: 1.1

10 БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ

Файлын нэр	RD-10-PLN-0002-M-Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө
Тодорхойлолт	Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө
Эхийг зохиогч	О.Цэрэннадмид, Газар болон соёлын өв хариуцсан ахлах мэргэжилтэн
Үүсгэсэн огноо	2013.09.01
Баталсан албан тушаалтан	Ш.Байгальмаа, Бүсийн хөгжил нийгмийн харилцааны хэлтсийн ерөнхий менежер
Баталсан огноо	2013.09.01
Өөрчлөлтийг бүртгэх дугаар	#

Эрсдлийн зэрэглэл	Үнэлгээ хийсэн огноо	Хийсэн	Үнэлгээ хийсэн албан тушаалтан	Хянах хугацаа	Дараагийн хянах огноо
Дунд	2013.09.01		О.Цэрэннадмид	2 жил	2015.09.01

Хувилбар	Хянан засварласан огноо	Зохиогч	Баталсан	Хянан засварласан тэмдэглэл
1.0	2013.09.01	О.Цэрэннадмид	Ш.Байгальмаа	Баталсан.
1.1	2013.11.23	Л.Мөнхцацрал	Ш.Байгальмаа	Баримт бичгийн дугаарлалтыг засч, баримт бичгийг хянав.